

НОМ ӨГҮҮЛЛИЙН ШҮҮМЖ

“БНМАУ-ЫН ТҮҮХИЙН ЗАРИМ АСУУДАЛ

(маоист завхруулгын эсрэг) УБ., 1984”

(шүүмж)

Дорнодахины судлалын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлсэн “БНМАУ-ын түүхийн зарим асуудал” хэмээх өгүүллүүдийн эмхэтгэлд Монголын ард түмний олон зуун жилийн түүхэн хөгжил, түүний өвөрмөц соёл иргэншил, 1921 оны ардын хувьсгал, БНМАУ-ын капиталист бус хөгжил, социалист байгуулалтын ололт амжилтыг Хятадын түүхчид хэрхэн гуйвуулж байгааг авч үзжээ.

“Монгол нутаг дээр тогтнож байсан эртний улсууд”, “археологийн баримт ба феодалын түрүү үеийн Монголын түүхийн үнэн” хэмээх эхний 2 өгүүлэлд Монгол нутагт нэн эрт цагаас хүн аж төрж байсан бөгөөд хамгийн эртний нүүдлийн мал аж ахуйн нэг төв байсныг гаргаж, Монгол нутагт оршин тогтнож байсан аймгийн холбоонуудаас эх үүсвэрээ авсан эртний улсуудын нийгэм-эдийн засгийн үндсэн дээр Монголын нэгдсэн төр байгуулагдаж, монгол угсаатан бүрэлдэн тогтсон, тэдгээр улс нь хэзээнээс нааш тусгаар тогтнон, бие даасан төрийн бодлого явуулж, нүүдлийн соёл ахуйгаа хөгжүүлэх хөрш Хятад оронтой аж ахуй, худалдааны харилцаатай байснаас биш, хэзээ ч Хятадын харьяанд орж байгаагүйг түүхийн баримт материалд тулгуурлан нотлон харуулсан байна.

Уг эмхэтгэлийн “Чингис хааныг магтаж байгаагийн учир”, “Юан гүрний үеийн Монголын түүхийг гуйвуулж байгааг шүүмжлэх нь” гэсэн өгүүллүүдэд Монголын нэгдсэн төрийг үндэслэн байгуулагч Чингис хаан, Юан улсыг байгуулсан Хубилай хааны түүхийг Хятадын зарим түүхчид улс төрийн тодорхой зорилгод ашиглах үүднээс өөрсдийн бүтээлдээ Хятадын доторх цөөнх үндэстнүүдийн дундаас төрөн гарсан төрийн зүтгэлтнүүд хятад үндэстнийг нэгтгэж, нэгдмэл Хятад улсыг байгуулахад гарамгай гавьяа байгуулсан гэх буюу “Хубилай бол манай нэгдсэн олон үндэстний улсын хөгжилтөд гарамгай хувь нэмэр оруулсан юм” гэж хятадын ард түмнийг байлдан дагуулсан түүхэн үнэнийг гуйвуулж, Азийн олон улс орныг эзэлсэн Монголын Юан гүрэн гэж байгаагүй, гагцхүү Хятадын нэгдсэн Юан улс байсан гэж үзсэн зэргийг шүүмжилжээ.

“XIV зууны сүүлчээс XVII зууны эхэн хагасын Монголын түүхийн асуудал” хэмээх өгүүлэлд феодалын бутралын үеийн Монголын түүхийг хятадын Мин улсын үеийн Монголын түүх гэдэг нэр зүүж мушгин гуйвуулж, Тогоонтөмөрөөс хойш Монголын төр бүрмөсөн больж Монгол Улс Мин улсын “дотоод хэсэг” болсон мэтээр гүтгэж тухайн үеийн Монголын хаадыг Хятадын нэгэн хэсгийг захирсан хаан байсан мэтээр үзсэнийг няцаажээ.

“Монгол дахь Манжийн ноёрхол”, “Маоист түүхчдээс Богд хаант Монгол Улсын түүхийг завхруулж байгаа нь” гэсэн өгүүллүүдэд Манжийн түрэмгийлэгчид Монгол, Хятадын аль алины тусгаар тогтнолд халдан довтолж, ноёрхолдоо оруулж дарлан мөлжиж байснаас үзэхэд Монгол орон Хятадын нэгэн хэсэг хэзээ ч байгаагүй, харин өөрийн өвөрмөц хэл, соёлоо хадгалан, харийн түрэмгийлэгчдийн эсрэг нэг бус удаа тэмцэн босож, эцсийн эцэст төр улсын тусгаар тогтнолоо байлдан олсон тухай дурджээ. Хятадын зарим түүхчид Манжийн түрэмгийллийг “дэвшилт үзэгдэл” “төвшитгөн тогтоосон” хэрэг мэтээр үзэж, Монгол орон анхнаасаа Хятадын “салшгүй хэсэг”, Манжийн эсрэг хийсэн Монголын ард түмний тэмцлийг Хятад орны бүрэн бүтэн байдал, нэгдэл нягтралыг задлахад чиглэсэн харгис үйл явдал, Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг удирдагч, зүтгэлтэн нарыг “Хятад эх орноос урван тэрслэгчид” зэмлэн бичдэг байна. Тэд Манжийн эсрэг Монголд өрнөсөн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг үгүйсгэн, түүний үр дүнг “Оросын хатгалгаар Богд тэргүүтэй цөөнхи феодалууд тусгаар тогтнолоо тунхагласан мэтээр мушгин гуйвуулдгаар үл барам “Хаант Орос манай улсын Цагаан хэрмийн хормой хүртэл хил хязгаараа тэлэх оролдлого хийж байсан” мэтээр гүтгэжээ. Ийнхүү түүхэн үнэнийг завхруулж байгаа нь архивын болон сурвалж бичгийн материалтай харшилж байгааг дээрхи өгүүллүүдэд бодит баримтаар илчлэн бичсэн байна.

“1921 оны Монгол ардын хувьсгал ба БНМАУ-ын капиталист биш хөгжил”, “БНМАУ-ын социалист байгуулалтын ололтыг маоист түүхчид гуйвуулж байгааг шүүмжлэх нь” гэдэг өгүүллүүдэд Октябрийн хувьсгалын шууд нөлөөгөөр Монгол оронд ардын хувьсгал ялж, ЗХУ-ын ах дүүгийн сэтгэл харамгүй интернационалч тусламжийн ачаар капитализмыг алгасан социалист нийгмийн амжилттай байгуулж, социализм нь өнөөгийн Монголын ард түмний бодит амьдралд хэрэгжсэн зүйл болсныг Хятадын зарим түүхчид элдвээр мушгин гуйвуулж байгааг гаргажээ. Хятад цэргийн эрхтэн Монголыг эзлэн түрэмгийлж Хятадад нэгтгэх бодлого явуулж, ард түмнийг дарлан доромжилж байсныг тэд огт дурьдахгүй, харин Монголын ардын хувьсгалыг “Оросын эсрэг” чиглэсэн мэтээр түүхэн үнэнийг мушгин гуйвуулсан байна. Бас ардын хувьсгалыг бие даасан оронд гарсан биш “Хятадын хязгаар нутагт гарсан үндэстний цөөнхийн хувьсгал” гэх буюу “Хятадын газар нутгийн нэг хэсэг болох” Гадаад Монголд ардын хувьсгал мандсан, Хятадын янз бүрийн үндэстнүүд Монголд нутаглаж байсан учир монгол, “хятад” зэрэг үндэстнүүдээс явуулсан хувьсгал мэтээр Хятадын зарим түүхчид гуйвуулж бичжээ. Тэд Монголд өрнөсөн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, ардын хувьсгалын ангич шинжийг үгүйсгэж, “Хятадын үндэстнүүдээс явуулсан дотоодын тэмцэл” мэтээр дүрслэх буюу хувьсгалын гол хөдлөх хүч болсон Монголын ард түмний гүйцэтгэсэн шийдвэрлэх үүргийг бууруулж, харин оролцоогүй буюу оролцох боломжгүй байсан гаднын хүчнийг дэвэргэж, Монгол Ардын хувьсгалын шинжийг өрөөсгөлөөр авч үзжээ. Түүнчлэн Монголын ард түмэнд үзүүлсэн ЗХУ-ын пролетарийн интернационалч тусламжийг “Хаант Оросын түрэмгий бодлогын үргэлжлэл” мэтээр бас тэд гүтгэн гүжирддэг байна. Хятадын зарим түүхчид БНМАУ-ын капиталист бус хөгжлийн замын ололт, социалист байгуулалтын амжилтыг хөгжиж байгаа орнуудаас нуун далдлахын үүднээс тэрхүү хөгжлийн зам, түүхэн туршлага, ач холбогдлыг муучлан мушгиснаараа ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн

бусад орон, тэр тусмаа БНМАУ-аас аль болохоор хөндийрүүлэхийг эрмэлзжээ. Гэтэл Монголын капиталист бус хөгжлийн туршлага, социалист бүтээн байгуулалтын ололт амжилтыг Ази, Африкийн чөлөөлөгдсөн олон улс орон улам бүр сонирхон судалж, өөрийн оронд бүтээлчээр хэрэглэхийг эрмэлзэж байгаа нь хэн ч юугаар ч үгүйсгэж чадахгүй бодит үнэн мөн билээ.

Дээрхи эмхэтгэлд орсон өгүүлүүдийг авч үзэхэд Хятадын зарим түүхчид Монголын түүхийн чухам аль үеэр юуг нь хэрхэн гуйвуулж байгаа, гэтэл тэр нь яагаад түүхэн үнэнд харшилж байгаа, чухам байдал ямар байсан зэргийг олон түмэнд мэдүүлэхэд уг бүтээл зохих хувь нэмэр оруулах нь дамжиггүй юм. Энэ бүтээлд Монголын түүхийн холбогдолтой зарим шинэ баримт, шинэлэг санаа дэвшүүлэн тавьсан нь онол, эрдэм шинжилгээний ул үндэстэй болсон байна. Харамсалтай нь түүнд голдуу хэвлэл, техникийн талын зарим алдаа мадаг байгааг анхаарч, залруулгын дагуу унших шаардлагатай байгаа харагдана.

Ц.Гэрэл